

ӨГҮҮЛЭЛ

Зүүн Азийн Аюулгүй байдлын хамтын ажиллагаа ба Монгол Улсын оролцоо

Ю.Солонго^{ID}*

БНХАУ-ын Ардын их сургуулийн Олон улсын харилцааны сургууль,
Бээжин, Бүгд Найрамдах Хятад Ард Улс
solongo.ush@gmail.com

Ч.Рэнцэн^{ID}

Бээжингийн их сургуулийн Нью медиа судалгааны хүрээлэн,
Бээжин, Бүгд Найрамдах Хятад Ард Улс
rentsen.c@gmail.com

Хураангуй: Монгол Улсын энхийг эрхэмлэгч, нээлттэй, олон талт, тэнцвэртэй гадаад бодлогын бүрэлдэхүүн болох бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох механизмыг бүрдүүлэх зорилгоор Зүүн Азийг дайн дажингүй, эдийн засгийн хөгжлийн хувьд тогтвортой бүс болгоход чиглэсэн Монгол Улсын хувь нэмэр, оролцооны асуудлыг судлан шинжилсэн байна. Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ”, цөмийн зэвсэггүй бүс болох Монгол Улсын хүчин чармайлт, Зүүн Азийн эдийн засгийн интеграцид хамрагдах оролдлого, тус бүсийн хөгжингүй орнуудтай (Япон, БНСУ) “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээн дэх идэвхтэй хамтын ажиллагаа, НҮБ-ын энхийг сахиулах үйл хэрэгт Монголын оролцоо зэрэг чиглэлээр гүнзгийрүүлэн авч үзжээ. Олон улсын харилцаан дахь геополитикийн өөрчлөлт, дэлхийн бодлогын шинэ сорилтууд нь Зүүн Азийн аюулгүй байдалд багагүй хүндрэл, бэрхшээл дагуулж буйг тэмдэглэхийн сацуу судлаачийн санал, дүгнэлтийг өгүүллийн төгсгөлд танилцуулав.

Түлхүүр үгс: “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилга, цөмийн зэвсэггүй бүс болох Монгол Улсын статус, гуравдагч хөршийн бодлого, худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагаа, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа

* Corresponding author

© The Author(s), 2025



<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

^{ID} <https://orcid.org/0009-0008-2203-2069>

^{ID} <https://orcid.org/0009-0002-9524-1650>

Received: 01 July, 2025
Accepted: 25 August, 2025

Өмнөтгөл

Монгол Улс 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш дэлхий нийтийн даяаршлын хөгжилд хамрагдах болсон билээ. Өмнө нь тухайн үеийн ЗХУ тэргүүтэй социалист хамтын нөхөрлөлийн бүрэлдэхүүн хэсэг байж дундад зууны үеийн хоцрогдлыг даван туулж, бичиг үсэгтэн ард түмэн болж, орчин цагийн эрүүл мэнд, соёл, боловсрол, шинжлэх ухааны суурь тавигдсан орон болж өөрчлөгдсөн. Эдийн засагт шинэ цагийн тээвэр харилцаа холбоо хөгжиж, уламжлалт мал аж ахуй давамгайлсан ч газар тариалан, хөнгөн аж үйлдвэрийн салбарууд, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр үүсэж бий болсон. Гэхдээ үзэл сурталжсан нэг намын төр-засгийн тогтолцоо, захиран тушаах төвлөрсөн удирдлага эдийн засагт зонхилж байв.

1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгал нь улс төрийн олон ургалч үзэл, эдийн засагт чөлөөт өрсөлдөөн, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх зарчмыг нийгмийн амьдралд хэвшүүлэх эхлэлийг тавив. 1993 онд шинэ Үндсэн хуультай болж Монгол Улсад хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоох, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, зах зээлийн эдийн засагт шилжих, улс төрийн ардчилсан шинэчлэлийг хэрэгжүүлэх томоохон зорилтуудыг дэвшүүлсэн ба нээлттэй, бие даасан гадаад бодлого баримтлахаа тунхагласан. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд “... олон улсын эрх зүйг нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”¹ гэж тодорхойлсон билээ. 1994 онд

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлал (хожим 2011 онд нэмэлт өөрчлөлт орсон) батлагдаж түүнд гадаад бодлогын үндсэн чиглэл, зарчмыг илүү нарийвчлан тодорхойлсон.

Хөрш хоёр улс ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт бөгөөд тэдгээр улстай бүхэлд нь тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлэхээр тусгасан. Мөн АНУ, БНЭУ, БНСУ, БНТУ, Япон Улс зэрэг өрнө, дорнын хөгжингүй улс, Европын Холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхээр заасан. Түүнчлэн Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох талаар тодорхой тусгасан. Энэ нь үндэсний аюулгүй байдлаа улс төр дипломатын аргаар хангах бодлогын хүрээнд бүс нутгийн тогтвортой байдлыг хангахад тодорхой хувь нэмрээ оруулан идэвх санаачилгатай ажиллах суурь болж, уг зорилтоо хэрэгжүүлэхийн тулд Монгол Улс багагүй чармайлт гарган олон талт үйл ажиллагаа явуулж ирэв.

Зүүн Азийн аюулгүй байдалд Монгол Улсын гүйцэтгэх үүрэг нь тус

¹ Монгол Улсын Үндсэн хууль, эрхл. Ж. Амарсанаа, Д. Баянбилэг, Т. Мэндсайхан (Улаанбаатар, 2018), 8..

улсын геополитикийн байршил, төвийг сахисан гадаад бодлого, дипломатын идэвхтэй оролцоонд суурилан олон чиглэлд санаачилга гарган тодорхой үр дүнд хүрч олон улсын дэмжлэгийг хүлээж ирсэн байна. Хэдийгээр цөөн хүн амтай жижиг улс боловч Монгол Улс Зүүн Азийн аюулгүй байдлын орчинд тодорхой хувь нэмэр оруулж, яриа хэлэлцээний талбар, итгэлцлийн гүүр болсоор байна. Зүүн Азийг дайн дажингүй, энхийг эрхэмлэсэн тогтвортой хөгжлийн бүс болгон хөгжүүлэх гол зорилтод Монгол Улсын

хүчин чармайлт, санаачилга төвлөрч ирсэн.

Монгол Улс гадаад харилцааны бодлогоо батлах явцад хоёр хөрштэйгөө бүхэлдээ тэнцвэртэй харьцах харилцааг нэн тэргүүнд чухалчилж үзсэн юм. “Тэнцвэртэй харилцах” бодлого гэдэг нь Орос, Хятад хоёр улстай улс төрийн адил тэнцүү бодлого баримтлах явдал биш бөгөөд харин тэдэнтэй харьцах эрх ашгийн харилцаанд дундын тэнцвэртэй байдлыг барих явдал юм.²

Зүүн Азийн аюулгүй байдал: Монгол Улсын хувь нэмэр, санаачилга

Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ (UBD)

Зүүн хойд Азид энх тайвныг бэхжүүлэхийн тулд дайн, зэвсэгт мөргөлдөөнгүй газар нутаг болгох нь тус бүсэд оршин буй улс орнуудын тогтвортой хөгжлийн нөхцөл хангагдана гэж Монгол Улс үзэн 2013 онд тодорхой санаачилга дэвшүүлсэн.

Солонгосын хойгт энх тайвныг тогтоох энэхүү санаачилга нь Монгол Улс нь дайны уршгаар хоёр хуваагдсан БНАСАУ (хойд), БНСУ (өмнөд) хоёр улстай эртний түүхэн уламжлал, XX-XXI зуунд сайн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн хүчин зүйлд тулгуурласан. Хойд Солонгос нь 1948 онд БНМАУ-тай дипломат харилцаа тогтоосон хоёр дахь улс (ЗХУ-ын дараа) бөгөөд тэр цагаас хоёр талд ЭСЯ-даа байгуулан холбоо харилцаагаа хөгжүүлж хамтран

ажилласан түүхтэй. 1950-иад оны Солонгосын дайны үеэр дайны хүндрэлийг даван туулахад БНМАУ хүмүүнлэгийн туслалцаа үзүүлж 200000 толгой мал хандивлаж, 200³ гаруй өнчин солонгос хүүхдүүдийг Монголд авчран өсгөн хүмүүжүүлж байсан түүхтэй. БНАСАУ болон БНМАУ нь тэр цагт ЗХУ тэргүүтэй социалист лагерьд хамаарч байв.

Өмнөд Солонгостой Монголд ардчилсан хувьсгал өрнөсний даруй 1990 оны 3-р сард дипломат харилцаа тогтоож 2006 оны “Сайн хөршийн, найрамдалт хамтын ажиллагааны түншлэл”, 2011 оны “Иж бүрэн түншлэл”-ийн зарчимд тулгуурлан хамтран ажиллаж ирсэн ба тэрээр манай улсын “гуравдагч хөрш” орны нэг бөгөөд Монгол Улсад

² Сайхансанаа, Х., Д. Даш, “Хүйтэн дайны дараах Монгол Улсын гадаад харилцааны бодлого ба ‘олон тулгуурт’ гадаад харилцааны бодлого,” *Journal of International Studies* 2 (2015), нэвтрэх хуудасгүй, <https://doi.org/10.5564/jis.v0i2.389>

³ *Mongolian Geopolitics* (Ulaanbaatar: Friedrich Ebert Stiftung; Mongolian Institute for Innovative Policies, 2022), 58.

гадаадын хөрөнгө оруулалтаар 2-т, гадаад худалдаанд 4-т⁴ ордог түнш орон билээ. Тиймээс Хойд Солонгос цөмийн зэвсгийн туршилт хийж, БНСУ болон Япон, Зүүн хойд Азийн аюулгүй байдалд заналхийлж ирсэн эмзэг асуудлын хувьд яриа хэлэлцээ хийх урьдач нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн энх тайванч санаачилга дэвшүүлсэн. Тиймээс ч Монгол Улс ЗХА-ийн бүс нутгийн улсуудтай эрх тэгш харилцдаг давуу талаа ашиглан Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилгыг 2014 оноос эхлэн тодорхой ажил хэрэг болгон зохион байгуулж ирсэн.

Эдүгээ “Улаанбаатарын яриа хэлэлцээ” нь зөвхөн бүс нутгийн төдийгүй, олон улсын байгууллагууд, харилцаа, хамтын ажиллагаатай улс орнуудын сонирхлыг татсан арга хэмжээ болж өргөжсөн. Ялангуяа их гүрнүүдийн хооронд геополитикийн өрсөлдөөн даамжирч, улс орнуудын гадаад бодлогын орон зай хумигдаж байгаа өнөө үед өөрийн улсын геостратегийн онцлог, дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлыг тогтворжуулахад оруулж болох бодит хувь нэмэр, нөхцөлийг харгалзан үзэж бага хурлын үйл ажиллагааг өргөжүүлж ирснээр хуралд оролцогч байгууллага болон судлаачдын тоо жилээс жилд нэмэгдэн бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн яриа хэлэлцээний механизм болсон байна.

Тус олон улсын бага хурал нь 5 үндсэн хэсэгтэй ба тус бүрдээ сонирхол татсан сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлдэг. Эхний хуралдаанаар Зүүн хойд Азийн орнууд төдийгүй

бусад улсын судлаач нар бүс нутгийн аюулгүй байдлын сорилт, боломжуудын талаар ярилцдаг бол хоёрдугаар хуралдаанаар бүс нутагт итгэлцлийг бэхжүүлэх арга замын талаар хэлэлцэж ирсэн. Түүнчлэн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, эрчим хүч, залуучууд, цаг уурын өөрчлөлт зэрэг цаг үеийн чухал сэдвүүдийг 3-5 дугаар хуралдаанаар хөндөж ярилцдаг.

Мөн “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын хуралд оролцогч улсуудын Гадаад харилцааны яамны удирдах албан тушаалтан, олон улсын байгууллагын төлөөлөгчдийн тэргүүнийг оролцуулсан “хаалттай” нэгдүгээр сувгийн хуралдааныг Гадаад харилцааны яам хариуцан зохион байгуулдаг.

Монгол Улсын энэхүү санаачилгыг НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн Эдийн засаг, нийгмийн комисс дэмжин, хамтран зохион байгуулагч олон улсын байгууллага болсон. Мөн НҮБ-ын Улс төрийн газар “Бүс нутгийн залуучуудын салбар хуралдаан”-ыг 2019 оны хурлаас эхлэн хамтран зохион байгуулж ирсэн.

“Улаанбаатарын яриа хэлэлцээ”-г 2014 оноос хойш тасралтгүй зохион байгуулсны үр дүнд энэ хурал манай гадаад бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй, Монгол Улс болон тухайн бүс нутгийг сонирхдог эрдэмтэн, судлаачид, дипломатуудын анхаарлыг татсан арга хэмжээ болоод байна. Олон улс, шинжээчдийн сонирхлыг татаж буй Монгол Улсын төвийг сахисан, энх тайванч гадаад бодлого, байр суурийг дэлхийн улс орнуудад таниулах, улмаар бүс нутгийн хамтын ажиллагааны төв болох боломж,

⁴ Мөн тэнд, 61.

нөхцөлийн талаар хэлэлцэх тус бага хурлаар Төв Ази, ЗХА-д тулгарч буй аюулгүй байдлын сорилтуудыг судлах, аюулгүй байдлын яриа хэлэлцээний механизмын төлөвшлийг дүгнэж, эцэст нь бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд Монгол Улсын гүйцэтгэж болох үүрэг, байр суурийг тодорхойлоход чухал механизм болж буй юм. Энэ ч утгаараа Улаанбаатар хот нь Төв Ази болон ЗХА-ийн хувьд яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны шинэ талбар буюу “Шинэ Хельсинки” болох боломжийг онолын хувьд тодорхойлон дэвшүүлэх, практик ач холбогдлыг томъёолохыг манай судлаачид эрмэлздэг.

Улмаар “Улаанбаатарын яриа хэлэлцээ” хурал зөвхөн ЗХА-ийн улсаар хязгаарлагдахгүй, НҮБ, Европын Холбоо зэрэг олон улсын томоохон байгууллагууд, манай “гуравдагч хөрш”-ийн улс орнууд идэвхтэй оролцдог, жил бүрийн 6

дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулагддаг Зүүн Ази болон Төв Азийн хоёр бүс нутгийг холбосон арга хэмжээ болох ирээдүйтэйг харуулж байгаа билээ. “Улаанбаатарын яриа хэлэлцээ”-ний Х бага хурал 2025 оны 6-р сарын 5-6-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо болж 40 улс, 5 олон улсын байгууллагын 250 орчим төлөөлөгч, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн төлөөлөл оролцож үндсэн таван салбар хуралдаанаар бүс нутгийн аюулгүй байдлын асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх, итгэлцлийг бэхжүүлэх чиглэлд санаа бодлоо илэрхийлж, ажил хэрэгч байдлаар зохион байгуулагдав. Ийнхүү “Улаанбаатарын яриа хэлэлцээ” бага хурлын цар хүрээ жил ирэх тусам өргөжин тэлж, аюулгүй байдлын асуудлаарх бүс нутгийн тогтвортой яриа хэлэлцээний нэг чухал механизм болж төлөвшив.

Цөмийн зэвсэггүй статус ба аюулгүй байдлын загвар

Монгол Улс анх 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн индэр дээрээс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан билээ. Энэ цагаас хойш НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн, цөмийн зэвсэгтэй таван гүрнээр цөмийн зэвсэггүй бүс хэмээн хүлээн зөвшөөрүүлэх, мөн аюулгүй байдлын баталгаа гаргуулж авахыг оролдож ирсэн.

Цөмийн зэвсэгтэй таван гүрний ашиг сонирхлоос үүдэн Монгол Улсыг цөмийн зэвсэггүй “бүс” гэсэн тодорхойлолтоор бус, харин “статус” гэдгээр зөвшөөрсөн юм. Манай талаас олон талт хүчин

чармайлт санаачилга гарган идэвхтэй үйл ажиллагаа явуулсан. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс хоёр жил тутам Монгол Улсаас өргөн барьж буй олон улсын аюулгүй байдал болон цөмийн зэвсэггүй бүсийн статусын талаарх илтгэлийг хэлэлцэхийг зөвшөөрсөн тогтоолыг арав гаруй удаа баталсан байдаг. Цөмийн зэвсэг бүхий улсуудтай явуулсан яриа хэлэлцээний дүнд Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжих зорилгоор дээрх улсууд 1995, 2000 онд Хамтарсан мэдэгдэл гаргасан байна. Монгол Улс нь 2000 онд олон улсын түвшинд үлгэр жишээ үзүүлэн хууль тогтоох

байгууллагаас “Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль”⁵ батлан мөрдөж байгаа билээ. Дэлхий дахинд цөмийн зэвсэггүй бүс болохоо зарлаж идэвхтэй үйл ажиллагаа явуулсны үр дүнд 2012 онд Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн, цөмийн зэвсэгтэй 5 гишүүнээр улс төрийн баталгаа гаргуулж чадсан.⁶ Энэ нь хоёр их гүрний дунд оршдог Монгол Улсын хувьд тусгаар тогтнол, аюулгүй байдлаа бататгах, бүс нутгийн аюулгүй байдал, итгэлцлийг бэхжүүлэх чиглэлээр явуулж буй гадаад бодлогын томоохон амжилт болсон. Олон жилийн турш цөхрөлтгүй хэрэгжүүлж ирсэн дипломат ажиллагааны үр дүнд өдгөө Монгол Улс нь дэлхийд цорын ганц цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлагдсан орон болсон билээ.

Өнөөдөр Монгол Улсын хувьд цөмийн зэвсэггүй бүсийн статусаа Орос, Хятад улсуудтай гурван талт гэрээгээр эрх зүйн үндэслэл, баталгаатай болгоход чиглэсэн

бодлого, үйл ажиллагаа явуулахаас гадна цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх хөдөлгөөнийг идэвхтэй дэмжиж байна. Монголын талын цөмийн зэвсгийн эсрэг, түүнийг үл дэлгэрүүлэх талаар баримталж байгаа байр суурь, санаачилга нь ижил төстэй байр суурь, үзэл санаа бүхий улс, улс бус тоглогчидтой илүү ойр дотно харилцах боломжийг олгож байна. Түүнчлэн Монголын санаачилга нь Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн болон АСЕАН-ы итгэлцлийг бэхжүүлэх зорилт, Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээг дэмжигч орнуудын зорилтуудтай нийцэж байдаг. Мөн манай улсын хувьд Зүүн өмнөд Ази болон Төв Азийн цөмийн зэвсэггүй бүсүүдтэй хамтран өөрийн статусыг баталгаажуулах, Япон зэрэг Зүүн Азийн ижил төстэй орнуудтай хамтран цөмийн зэвсэггүй бүс байгуулах талаар санаачилга гарган ажиллах боломжтой юм.

Гуравдагч хөршийн бодлого ба тэнцвэржүүлэлт

Монгол Улс дэлхийд хамгийн том газар нутагтай, мөн хамгийн олон хүн ам, цөмийн зэвсэгтэй, өөр өөрийн бие даасан онцлог байр суурьтай хоёр томоохон улс - ОХУ, БНХАУ-ын дунд оршдог. Олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших чиг хандлага ажиглагдаж буй болон геополитикийн эрчимтэй өөрчлөлтийн өнөө цагт хойд ба өмнөд хөрштэйгөө тэнцвэртэй харилцах, гурвалсан хөршийн хамтын ажиллагаа, “гуравдагч хөрш”-ийн бодлогын хооронд эрх ашгийн тэнцвэрийг зохист түвшинд барих

үндсэн дээр ухаалаг тэнцвэрийн хүчийг олох нь бидний хувьд чухал хэрэгцээ болж байна.

“Гуравдагч хөрш”-ийн бодлого нь аль нэг хүчирхэг улсыг чухалчлан үзэх зорилго агуулдаггүй. Харин дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд нөлөө бүхий улс орнууд болон хөгжингүй эдийн засгийг энэ бодлогодоо багтаадаг бөгөөд Монгол Улс эдгээр улсуудын эдийн засгийн ашиг сонирхол, хөрөнгө оруулалтыг татахыг хичээсээр байна. Энэ хүчин чармайлт амжилттай хэрэгжиж байгаагийн нэгээхэн хэсэг

⁵ Монгол Улсын Үндсэн хууль (1992), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=579>

⁶ United Nations Digital Library. “General Assembly-Resolution A/RES/67/18.” <https://digitallibrary.un.org/record/735422?ln=en&v=pdf>

нь Оюу толгойн зэсийн уурхай болон Улаанбаатарын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг байгуулахад оруулсан хөрөнгө оруулалт юм.

“Туравдагч хөрш”-ийн бодлого нь хатуу- тэнцвэржүүлэгч элементүүдийг (цэргийн эвсэлд нэгдэх, батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, цэргийн техник хэрэгслээр хангах г.м) багтаадаггүй. Харин улс төр, эдийн засаг, соёлын хамтын ажиллагаа зэрэг зөвхөн зөөлөн-тэнцвэржүүлэгч элементүүдэд анхаарлаа хандуулдаг. Хэдийгээр Умард Атлантын Гэрээний Байгууллага (НАТО) түүний гишүүн орнуудтай Монгол Улс түншлэлийн харилцаатай боловч батлан хамгаалахын хамтын ажиллагаа нь Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулах чадавхыг хөгжүүлэх, батлан хамгаалах салбарын дипломат солилцоог тогтмолжуулах (яриа, айлчлал, оюутны тэтгэлэг) үйл ажиллагаагаар шууд хязгаарлагддаг. Өөрөөр хэлбэл, энэ бодлого нь Монголыг бүс нутгийн геополитикийн хурцадмал байдлаас харьцангуй хамгаалж, Зүүн Азийн аюулгүй байдлын яриа хэлэлцээнд бие даасан дуу хоолойтой оролцох боломжийг олгож байдаг.

Зүүн Азийн нөлөө бүхий, зах зээлийн эдийн засаг сайн хөгжсөн Япон, БНСУ нь Монгол Улсын чухал “туравдагч хөрш” түнш орон гэдгийг энд онцлон хэлэх хэрэгтэй. Япон улс нь Монгол Улсыг зах зээлийн эдийн засаг, ардчилсан улс төрийн шилжилтийг хэрэгжүүлэхэд дэмжигч хандивлагч орон байж, Дэлхийн Банк, ОУВСан, Азийн хөгжлийн банканд гишүүнээр элсэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Япон Улсын дэмжлэг нь орон нутгийн түвшинд хүмүүсийн аж амьдралыг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжил, хүмүүнлэгийн тусламжид илүүтэй төвлөрдгөөр онцлог. “Долоогийн бүлэг”, “20-ийн бүлэг” болон Европын Эдийн засаг Хамтын ажиллагааны байгууллагаас түрүүлж Япон Улс нь 2015 онд Монгол Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулж, хөрш хоёр орноос эдийн засгийн хувьд хараат байдалд буй Монголын эдийн засаг, экспортыг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Азийн хөгжлийн банкаар дамжуулан Япон Улс нь 300 гаруй дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлж, Улаанбаатарын шинэ Олон улсын нисэх буудлыг бага хүүтэй зээлээр барьж байгуулсан.

Монгол Улс нь БНСУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах бэлтгэл ажил явагдаж буй бөгөөд дээр өгүүлснээр тэрээр Монгол Улсын гадаад худалдааны дөрөвдэх түнш юм. БНСУ нь 2018 оны байдлаар 239 сая ам долларын буцалтгүй тусламж, 143 сая⁷ ам долларын зээл, хөрөнгө оруулалтыг Монголд оруулж, шилжилтийн үеийн хүндрэлийг даван туулахад дэмжлэг үзүүлсэн. Хүн хоорондын харилцаа нь хоёр улсын харилцаанд чухал хүчин зүйл болдог бөгөөд 40000 гаруй монгол иргэд Өмнөд Солонгост ажиллаж, суралцаж байна. Солонгосын бизнес эрхлэгчид Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ба жил тутам 100000 иргэд хоёр орны хооронд зорчиж аялал жуулчлалыг хөгжүүлж байна.

⁷ *Mongolian Geopolitics* (Ulaanbaatar: Friedrich Ebert Stiftung; Mongolian Institute for Innovative Policies, 2022), 61–62.

Эдийн засгийн интеграци дахь оролцоо

XXI зуунд Монголын гадаад харилцаанд Зүүн хойд Азийн бүс нутаг онцгой байр эзлэх болов. Учир нь энэ бүс нутагт АНУ, Япон, ОХУ, БНХАУ гэсэн томоохон гүрнүүдийн эрх ашиг сонирхол төвлөрдөг. Тэгээд ч Монгол Улс тэдний ашиг сонирхлын хүрээнд багтаж буй юм. Далайд гарцгүй эх газрын Монгол орны хувьд дэлхийн зах зээлд татагдан орохдоо чухамхүү аль бүс нутгаар дамжин орох вэ гэдэг асуудал зүй ёсоор тавигдсан. Ази, Номхон далайн бүс нутаг, тодруулбал Зүүн хойд Ази хамгийн ирээдүйтэй гэдэг дээр манай олон улсын харилцааны тэргүүлэх судлаачдын санал төвлөрдгийг энд хэлэх хэрэгтэй. Монгол Улс нь Зүүн хойд Азийн бүс нутаг, тухайлбал ОХУ, БНХАУ-тай дамжин өнгөрөх тээвэр хийх, эдгээр улсын нутаг дэвсгэрийг ашиглаж, далайд гарц бий болгох тухай засгийн газрын түвшинд гэрээ хэлцэл хийсэн боловч одоогоор тодорхой амжилтад хүрээгүй байна.

Монгол Улсын Зүүн Ази дахь эдийн засгийн оролцоо нь голчлон уул уурхай, худалдаа, хөрөнгө оруулалт, бүс нутгийн интеграцчлалын хүрээнд хөгжиж байна. Зүүн Азийн эдийн засгийн хувьд Хятад, Япон, Өмнөд Солонгос зэрэг томоохон тоглогчидтой харьцуулахад Монголын оролцоо харьцангуй жижиг боловч байгалийн баялаг, газарзүйн байршлын хувьд стратегийн ач холбогдолтой билээ.

Монголын эдийн засаг ерөнхийдөө уул уурхайн салбарт түшиглэж буй (2024 оны байдлаар уул уурхайн салбар ДНБ-ий 25% орчим, экспортын

90% орчмыг бүрдүүлсэн) бөгөөд Зүүн Азийн зах зээл, ялангуяа Хятад улс нь нүүрс, зэс, төмрийн хүдэр зэрэг эрдэс баялгийн гол худалдан авагч юм. Сүүлийн жилүүдэд манай улсын нийт экспортын 90 гаруй хувийг БНХАУ дангаар бүрдүүлж байна. Оюутолгой, Тавантолгой зэрэг томоохон уурхайнуудын зэс, нүүрс зэрэг бүтээгдэхүүн Хятадын гангийн үйлдвэрлэл, эрчим хүчний хэрэгцээнд чухал хувь нэмэр оруулдаг. Харин нийт импортын 40 орчим хувийг БНХАУ, 25 орчим хувийг ОХУ, 10 орчим хувийг Япон улс, 4 орчим хувийг БНСУ тус тус эзэлж, эдгээр Зүүн Азийн улс нийт импортын 80⁸ орчим хувийг бүрдүүлж байна. БНХАУ-аас ачааны автомашин, гар утас, цахилгаан хэрэгсэл, химийн бүтээгдэхүүн, ОХУ-аас нефтийн бүтээгдэхүүн, Япон, БНСУ-с автомашиныг голлон импортоор оруулж байна.

БНХАУ-ын удирдагчийн дэвшүүлсэн “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд “Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор” байгуулахаар тохиролцсон (энэ санаачилга нь 2016 оны 6 дугаар сарын 23-нд Ташкент хотноо болсон гурван улсын төрийн тэргүүн нарын уулзалтын үеэр албан ёсоор батлагдсан) бөгөөд уг санаачилга нь гурван улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, худалдаа, тээвэр, дэд бүтцийн хөгжлийг дэмжих зорилготой хөтөлбөр юм. Хөтөлбөрийн гол зорилго нь худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, хил дамнасан тээврийг хөнгөвчлөх, дэд бүтцийн томоохон

⁸ Үндэсний статистикийн хороо, *Гадаад худалдаа – 2021* (Улаанбаатар: YCX, 2022), <https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Foreign%20trade%202021.pdf&ln=Mn>

төслүүдийг хэрэгжүүлэх замаар бүс нутгийн эдийн засгийн интеграцийг бэхжүүлэхэд оршиж буй.

Зүүн Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд Монгол Улс идэвхтэй оролцох санаачилга байвч багтаамж багатай жижиг зах зээл, байгаль цаг уурын эрс тэс уур амьсгал, олон улсын далай тэнгис, зам харилцаанаас алслагдсан байршил, түүнээс үүдэлтэй үйлдвэрлэлийн болон тээвэрлэлтийн өндөр өртөг нь манайд үр ашигтай үйлдвэрлэл эрхлэх боломжийг хязгаарлаж ирсэн. Тиймээс ч Монголын эдийн засаг өрсөлдөх чадвартай цөөн салбар, хэдхэн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд төвлөрч, гадаад зах зээл, гадаад орчноос хэт хамааралтай эмзэг нөхцөл байдалд орсон байдаг. Хэдийгээр Монгол Улс нь зах зээлийн эдийн засагт бүрэн шилжсэн ч өндөр технологи бүхий, нэмүү өртөг бүтээх уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах, мөн бусад боломжийн салбарт үндэсний үйлдвэрлэлийг дорвитой хөгжүүлж чадаагүйг хэлэх хэрэгтэй. Доктор Ц.Баатарын бичсэнчлэн “... манай улсын гадаад худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой олон боломж, хөнгөлөлттэй, нэн таатай нөхцөлийг НҮБ, ДХБ, ЕХ зэрэг олон улсын байгууллагууд олгож ирсэн ... түүнийг өнөө хэр бүрэн, үр дүнтэй, бүтээлчээр овсгоотой ашиглах механизм бидэнд дутагдаж байна”⁹ гэсэнтэй санал нэг

байна.

Дээр тэмдэглэснээр Япон улстай 2015 онд “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЕРА)” байгуулсан ба энэ хэлэлцээр нь Монгол Улсын анхны чөлөөт худалдааны хэлэлцээр байсан. Цаашид БНСУ, БНХАУ-тай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар яриа хэлэлцээ, судалгаа хийгдэж байна. Харин 2025 оны 6-р сарын 26- 27-ны өдрүүдэд Беларусийн Минск хотод болсон ЕАЭЗХ-ны Дээд зөвлөлийн хуралдаан, ЕвроАзийн эдийн засгийн ГҮ чуулганы үеэр Монгол Улс, ЕАЭЗХ-ны хооронд Худалдааны түр хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Энэхүү түр Хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэж байж хүчин төгөлдөр болно.

Монгол Улс АСЕАН-тай хамтарч ажиллах ихээхэн сонирхолтой байдаг хэдий ч улс төр, худалдаа эдийн засгийн үйл явцад дорвитой өөрчлөлт гаралгүй өнөөдрийг хүрсэн. Үүнд Монголын талаас газарзүйн байршил, жижиг зах зээл, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин бүрхэг зэрэг субъектив шалтгаан нөлөөлж ирсэн. АСЕАН-ы Найрамдал хамтын ажиллагааны гэрээ (ТАС)-нд нэгдэн орсон давуу талаа ашиглан АСЕАН-ы орнуудын хэрэгжүүлж буй зарим төсөл, хамтын ажиллагаанд санаачилгатай оролцохыг эрмэлзэх нь Зүүн Азийн интеграцид ирээдүйд нэгдэх хүсэлтэй Монгол Улсын бодлогод чухал алхам байх юм.

⁹ Ц.Баатар, “Монгол Улс бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох боломж, сорилт”, *Монгол Улсын гадаад харилцаа: Түүх, орчин үе* (Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академи, 2018), 91.

Олон улсын энхийг сахиулах үйлс дэх оролцоо

Монгол Улс 2002 онд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд анхны хоёр цэргийн ажиглагчаа илгээснээр НҮБ-ын энхийн ажиллагаанд цэрэг хандивлагч орнуудын жагсаалтад албан ёсоор бүртгэгдэж, оруулж буй хувь нэмрээрээ нийт 89 орноос 82 дугаарт бичигдэж байсан бол өнөөдөр 123 орноос 18¹⁰ дугаарт бичигдэж байна.

Монгол Улсын эдийн засгийн хэмжээ бага, хүн ам цөөн, зэвсэгт хүчин жижиг боловч НҮБ, НАТО-д оруулсан хувь нэмэр, үүрэг амлалтыг нь онцлон тэмдэглүүштэй бөгөөд олон улсад энхийг сахиулах ажиллагааны найдвартай түнш хэмээн үнэлэгддэг.

Монгол Улс энхийг сахиулах ажиллагаанд оролцохоос гадна олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн орчин үеийн энхийг сахиулах ажиллагааны сургалтын төв буюу “Таван толгой дахь Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв”-ийг байгуулсан. Тус сургалтын төв нь Энэтхэг, Герман зэрэг хамгийн томоохон зэвсэгт хүчнээс эхлээд Бельги, Катар зэрэг хамгийн

жижиг зэвсэгт хүчинтэй улс орнуудтай хоёр талын хамтарсан сургууль явуулах боломжийг олгодог. Жижиг боловч өвөрмөц онцлогтой “Хааны эрэлд” олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургууль дадлагыг энэ сургалтын төвд зохион байгуулж, Хятад, Япон, Өмнөд Солонгос, АНУ болон энхийн ажиллагаанд цэрэг хандивлагчаар түрэн гарч ирж буй улс орнуудыг нэгэн дор цугларч харилцан суралцаж, сургуулилт хийх таатай нөхцөлийг бүрдүүлдэг.

Монголын энхийг сахиулах ажиллагааны хүчин чармайлт нь өнөөгийн геополитикийн эрчимтэй өөрчлөлтийн олон улсын орчинд том, жижиг гүрнүүд бүтээлчээр хамтран ажиллах бүрэн боломжтойн тод жишээ юм. Хязгаарлагдмал цэргийн чадавхтай жижиг орны хувьд энхийг сахиулах ажиллагаа нь Монгол Улсын нэр хүндийг олон улсын тавцанд өсгөх, түүнчлэн олон улсын хамтын нийгэмлэгийн хариуцлагатай гишүүн байх “хүчирхэг” хэрэгсэл болж байна.

Санал, дүгнэлт

Сүүлийн жилүүдэд олон улсын харилцаан дахь геополитикийн эрчимтэй өөрчлөлт нь геополитикийн голлон тоглогч гүрнүүдийн харилцааг хурцатгаж улмаар бүс нутгийн аюулгүй байдалд нөлөөлөн том, жижиг орнуудын гадаад орчинд шинэ эрсдэлийг төрүүлсээр байна. Дэлхийн дэг журам нэг туйлт ертөнцөөс олон туйлт дэлхий рүү шилжих үйл явцад ойлгомжгүй, туйлширсан хандлага ажиглагдаж эхлэв. АНУ-ын шинэ засаг

захиргаа импортын бүтээгдэхүүнд гаалийн нэмэлт татвар тогтоон тарифын хатуу бодлого явуулж буй нь дүрэм журамд суурилсан олон талт худалдааны тогтолцоог ноцтой зөрчиж, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээ болон эдийн засгийн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна. Орос, Украины дайн нь Европ төдийгүй дэлхий дахины аюулгүй байдалд ноцтой хямралыг өдөөв. Тайванийн талаарх БНХАУ, АНУ-ын бодлого, БНАСАУ-ын

¹⁰ Unread. “How I Work: UN Peacekeeper Erdenebileg,” 2025 оны 3 дугаар сарын 18, <https://unread.today/c/howiwork-un-peacekeeper-erdenebileg>

баллистик пуужингийн туршилт нь Ази, Номхон далайн бүс нутгийн тогтворгүй байдлын шалтгаан болж энэ нь Зүүн Ази, Евроази, Төв Азийн аюулгүй байдал, нийгэм эдийн засгийн тогтвортой байдалд хүндрэлийг авчрав. Энэ шинэ нөхцөл нь Монгол Улсын гадаад орчинд шууд хамааралтай ба хөрш хоёр их гүрэн, бүс нутгийн бусад улс орнуудтай хүчний тэнцвэрийг зөв тооцсон энх тайванч, төвийг сахисан бодлого нэн чухал гэдгийг нотлон харуулсаар байна.

Монгол Улс Зүүн Азийн аюулгүй байдалд дипломатын идэвхтэй оролцоо, нейтрал байр суурь, яриа хэлэлцээний платформуор дамжуулан чухал үүрэг гүйцэтгэж байгаа билээ. Улаанбаатарын яриа хэлэлцээ, Солонгосын хойгийн энх тайвны үйл явцад оруулж буй хувь нэмэр, цөмийн зэвсэггүй статус, гуравдагч хөршийн бодлого, энхийг сахиулах үйлс дэх оролцоо нь Монголыг бүс нутгийн аюулгүй байдлын орчинд багагүй үүрэг оролцоотойг дэлхий дахинд харуулсаар байна.

Зүүн Азийн эдийн засгийн интеграцчилал нь Монгол Улсад худалдаа, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хөгжлийн боломжуудыг бий болгож буй ч газарзүйн хязгаарлагдмал байдал, дэд бүтцийн хөгжил сул, хөрөнгө оруулалтын орчин таатай бус зэрэг сорилтуудыг даван туулах шаардлагатай. Монгол Улс ASEAN, RCEP, BRI зэрэг олон талт хамтын ажиллагааны механизмыг ашиглан, мөн бүс нутгийн орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлснээр Зүүн Азийн интеграцчилалд илүү идэвхтэй оролцох боломжтой. Гэвч геополитикийн эрчимтэй өөрчлөлтөөс

үүдэн Монгол Улсын Зүүн Ази дахь эдийн засгийн хамтрагч болох БНХАУ, Япон, БНСУ болон уг бүсийн бусад улс оронд ирж буй тарифын бодлогын дарамт, олон талт хамтын ажиллагааны механизмын дүрэм журам өөрчлөгдөх эрсдэл нь шинэ сорилтыг бий болгож байна.

Монгол Улсын худалдааны гэрээнүүд нь гадаад худалдааг өргөжүүлэх, эдийн засгийн интеграцид нэгдэн түүнд оролцоотой байхад чиглэгддэг. Япон, БНСУ, Ази-Номхон далайн бүсийн улсуудтай хийсэн хэлэлцээрүүд нь зах зээлийг төрөлжүүлэх чухал хүчин зүйл болдог бол ЕАЭЗХ-ийн хэлэлцээр болон Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор нь бүс нутгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, олон талт эдийн засгийн хамтын ажиллагаанд илүү оролцоотой байх нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой. Монгол Улс нь гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн гаргах чадамжтай үндэсний үйлдвэрлэлээ эрчимтэй хөгжүүлэх зорилт нэн түрүүн тулгарч байна. Эс бөгөөс Эдийн засгийн түншлэлийн, Чөлөөт худалдааны Хэлэлцээрийн үр өгөөж нь нөгөө хамтрагч талд л ашигтай байх нь ойлгомжтой.

Цаашид геополитикийн тааварлашгүй өөрчлөлт, эрсдэлийг харгалзан дэлхийн бодлого, олон улсын харилцаанд тулгарах сорилтыг даван туулах зөв шийдэл, гадаад дотоод бодлогын уялдаа зохицуулалтыг бодитой хангасан гаргалгаа бүхий нэмэлт өөрчлөлтийг “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-д оруулах саналыг дэвшүүлж байна.

Ном зүй / References:

1. Баатар, Ц., “Монгол Улс бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох боломж, сорилт.” In *Монгол Улсын гадаад харилцаа: Түүх, орчин үе*, 91. Улаанбаатар: ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, 2018.
2. Хайсандай Л., *Монголын улс төрийн гадаад харилцааны түүх (1911–1999)*. Улаанбаатар, 2012.
3. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолын хавсралт.
4. Монгол Улсын Үндсэн хууль. Эрхлэн бэлтгэсэн Ж.Амарсанаа, Д.Баянбилэг, Т.Мэндсайхан. Улаанбаатар, 2018. ISBN 978-99962-825-8-4.
5. Монгол Улсын Үндсэн хууль (1992). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=579>.
6. *Монгол Улсын гадаад харилцаа: Түүх, орчин үе*. Улаанбаатар: ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, 2018.
7. Mongolian Geopolitics. Ulaanbaatar: Friedrich Ebert Stiftung; Mongolian Institute for Innovative Policies, 2022.
8. Сайхансанаа, Х., Д.Даш “Хүйтэн дайны дараах Монгол Улсын гадаад харилцааны бодлого ба ‘олон тулгуурт’ гадаад харилцааны бодлого.” *Journal of International Studies* 2 (2015). <https://doi.org/10.5564/jis.v0i2.389>.
9. United Nations Digital Library. “General Assembly—Resolution A/RES/67/18.” <https://digitallibrary.un.org/record/735422?ln=en&v=pdf>.
10. Үндэсний статистикийн хороо. *Гадаад худалдаа – 2021*. Улаанбаатар: ҮСХ, 2022. <https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Foreign%20trade%202021.pdf&ln=Mn>.
11. Unread. “How I Work: UN Peacekeeper Erdenebileg.” <https://unread.today/c/howiwork-un-peacekeeper-erdenebileg>

East Asian security cooperation and Mongolia's participation

LiYushin Solongo*

School of International Studies, Renmin University of China,

Beijing, China

solongo.ush@gmail.com

Rentsen Chinzai

Peking University,

Beijing, China

rentsen.c@gmail.com

Abstract: *This study closely analyzes Mongolia's participation and contribution to making East Asia a war-free and economically stable region, with the aim of establishing active mechanisms for regional cooperation as an integral part of Mongolia's peace-oriented, open, multilateral, and balanced foreign policy. The study deeply examines key directions including: the Ulaanbaatar Dialogue on Northeast Asian Security; Mongolia's efforts toward a nuclear-weapon-free zone; initiatives to join East Asia's economic integration; policies for active cooperation under the "third neighbor" strategy with developed countries in the region (Japan and South Korea); and ensuring active participation in United Nations peacekeeping activities. While noting that geopolitical changes in international relations and new global policy challenges pose significant difficulties to East Asian security, the study concludes by presenting its own views and findings on the issues.*

Keywords: *Ulaanbaatar Dialogue on Northeast Asian Security, Mongolia's status as a nuclear-weapon-free zone, trade and economic cooperation and the third neighbor policy, UN peacekeeping operations.*

The date of submission:

2025.07.01

Completion of review:

2025.08.17

Final decision for acceptance:

2025.08.25

* Corresponding author